



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 1/33

Хархорин сум

Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын "Газар өмчлүүлэх тухай" 2008 оны 31 дүгээр захирамжийн 45, 2005 оны 29 дүгээр захирамжийн 44, 2004 оны 60 дугаар захирамжийн 7, 2005 оны 130 дугаар захирамжийн 34 дугаарт байгаа 4 өрхийн нэр бүхий 14 иргэний өөрсдийн гаргасан хүсэлт, газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээг үндэслэн газар өмчлөх эрхийг шилжүүлсүгэй.

2. Тухайн газрыг гэр бүлийн аль нэг гишүүнд өмчлүүлж, бусад гишүүдэд газрыг хууль тогтоомжид заасны дагуу нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулахыг Газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ



401100095